



35

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/20

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх ажлуудад иргэдээс цахимаар болон багуудын Иргэдийн нийтийн хурлаас гарсан саналуудыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Оюун-Эрдэнэ

(Санхүүгийн албаны дарга)

Гишүүд:

Н.Пүрэвжаргал

(Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э.Балжинням

(Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Дэлгэрмаа

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Сувданцэцэг

(Нийгмийн хамгаалал, хүн ам зүйн асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

П.Баатар

(Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Нармандах

(Гэрэлтүүлгийн асуудал хариуцсан ажилтан)

Б.Баасанжаргал

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент,
малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Ц.Баасанбат

(Газар зохион байгуулалт, инженерийн шугам сүлжээ,
зам талбай хариуцсан ажилтан)

Б.Нармандах

(Газрын даамал)

(Багийн дарга нар)

С.Готов

(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

А.Цагаандолгор

(Тусгай сан хариуцсан Нягтлан бодогч)

2.Багуудаас ирсэн саналуудыг эрэмбэлж, сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Хүрэлсүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЭНХБАЯР